



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comsog@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.07.04 № 03/11536
танай _____-ны № _____-т

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай


Авлигатай тэмцэх газраас Хавдар судлалын үндэсний төвд ажиллах явцад тогтоогдсон нөхцөл байдал, иргэнээс тус төвийн үйлчилгээний талаар гаргасан өргөдөл гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дурдагдсан мэдээ, мэдээлэлтэй холбогдуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох ажил, арга хэмжээг зохион байгуулж, дүнг Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай.

Хувийг, Эрүүл мэндийн яаманд.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ

142303011846

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах Зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмж 1. Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/51 дүгээр “Журам, жагсаалт батлах тухай” тушаалыг хүчингүй болгох, цаашид хуулиар эрх олгоогүй тохиолдолд хэм хэмжээ тогтоосон захиргааны акт гаргахгүй байх;

Зөвлөмж 2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Төсвийн тухай хуульд заасан хориглосон, хязгаарласан хэм хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хуулиар зөвшөөрөөгүй төлбөр, хандив авахгүй байх;

Зөвлөмж 3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг байгууллагын дотоод нөөц боломжид тулгуурлан авч хэрэгжүүлэх, олон нийтийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй байгууллагын үйл ажиллагаанд холбогдох мэдээ, мэдээлэлд тогтмол дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирээгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх;

Зөвлөмж 4. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР